

Тодруулгад хариу хүргүүлэх нь:

2024 оны 12 дугаар сарын 09

“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр урилга илгээсэн ЭАРХХК/20240101250 тоот дугаартай “Уул-өрөмдлөг, Баримтлуулалт, Сорьцлолт /Хүрэн цав/-ын ажил” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалттай холбоотой оролцогчоос ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд :

№	Тодруулга	Хариу
1	<p>Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.3-д Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгодог “Цооног өрөмдөх, тоноглох, сэргээн засварлах гэрчилгээ”-тэй байхыг шаардсан. Захиалагчийн шаардсан гэрчилгээ нь Усны тухай хуульд зааснаар усны хайгуул, судалгаа явуулах, ус ашиглах зорилгоор худаг өрөмдөж цооног гаргах зэрэг үйл ажиллагаанд шаардагддаг баримт бичиг бөгөөд ЭАРХХК/20240101250 дугаартай тендер шалгаруулалтын үр дүнд хийгдэх ашигт малтмалын өрөмдлөгийн ажилд огт хамааралгүй юм. Түүнчлэн тендер шалгаруулалтын баримт бичиг болон гүйцэтгэх ажлын жагсаалтад ч мөн усны хайгуул хийх, худаг өрөмдөх ажил тусгагдаагүй. Иймд тус гэрчилгээ зайлшгүй шаардлагатай эсэх, мөн өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэхэд ач холбогдолтой эсэхэд тодруулга хүсэж байна.</p>	<p>Батлагдсан тендерийн баримт бичгийн ТШЗ 19.3-д “Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгодог:</p> <p>Цооног өрөмдөх, тоноглох, сэргээн засварлах хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх.” гэж тусгагдсаны дагуу үнэлгээнд харгалзан үзнэ.</p>
2	<p>Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1.Санхүүгийн чадавхын шаардлагын 4 дэх хэсэгт “Тендерт оролцогч нь 2021, 2022, 2023 онд ашигтай ажилласан байна” гэх шаардлага тусгасан. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т “Оролцогч санхүүгийн чадавхыг дараах баримт бичгээр нотолж болно”, 16.2.3-т “сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл” гэж заасан. Үүнээс үзэхэд тендер шалгаруулалтад оролцогч этгээдийн санхүүгийн чадавхыг үнэлэх шалгуур нь тухайн компанийн “борлуулалтын орлого” байна. Мөн компанийн борлуулалтын орлого хэдий өндөр хэдий ч тоног төхөөрөмжийн хүчин чадал сайжруулалт зэргээс шалтгаалан худалдан авалтын зардал өсөх, улмаар тухайн жилд ашиггүй ажиллах боломжтой байдаг тул тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг 3 жил дараалсан ашгаар хэмжих нь тохиромжгүй гэж үзэж байна. Иймд тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг борлуулалтын орлогоос гадна 3 жил дараалсан ашгаар шалгах шаардлагатай эсэх, энэ нь аливаа ач холбогдолтой эсэхэд тодруулга өгнө үү.</p>	<p>Батлагдсан тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д</p> <p>“Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”</p> <p>4. Тендерт оролцогч нь 2021, 2022, 2023 онд ашигтай ажилласан байна.” гэж тусгагдсаны дагуу үнэлгээнд харгалзан үзнэ.</p>